

БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН ЭРХ ЗҮЙН БАРИМТ БИЧИГТ БАГШ МЭРГЭЖИЛТНИЙ МЭДЛЭГ, ЧАДВАР, ХАНДЛАГЫН ТАЛААР ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Б.Ариунзаяа

Дотоод хэргийн их сургуулийн ЭШНХ-ийн боловсрол судлалын төвийн эрхлэгч, цагдаагийн хурандаа

Хураангуй: Ажил олгогч нь их, дээд сургуультай мэргэжилтэн сонгохдоо ур чадвар, хандлага, бүтээлч байдал, аман болон бичгийн өндөр түвшний харилцаа, тогтоосон хугацаанд найдвартай биелүүлэх, хичээл зүтгэл, тэсвэр тэвчээр, багаар ажиллах, мэдээлэлд шүүмжлэлтэй хандах, үнэлгээ, хариуцлага зэрэгт анхаарах хэрэгтэй. Энэ нь хүлээх, суралцах, сорилт бэрхшээлийг даван туулах, дасан зохицох, тэсвэрлэх чадвар, шинийг санаачлах, бизнес эрхлэх сэтгэлгээг хөгжүүлэхийг шаарддаг. Багшийн мэдлэг, ур чадвар, хандлагыг тодорхойлохдоо боловсролын болон эрх зүйн баримт бичиг, сургалтын хөтөлбөрийн үр дүнг янз бүрээр тодорхойлдог.

Abstract: Employers should pay attention to skills, attitude, creativity, high-level oral and written communication, the ability to reliably meet deadlines, diligence and perseverance, teamwork, a critical approach to information, assessment and responsibility when selecting a specialist with a university. It requires anticipation, learning, overcoming challenges, adapting, resilience, innovation, and developing an entrepreneurial mindset. Educational and legal documents and the results of the curriculum are defined in different ways when determining the knowledge, skills and attitudes of the teacher.

Түлхүүр үг: багш мэргэжилтэн, мэдлэг, чадвар, хандлага.

Key words: teacher, expert, knowledge, ability, attitude.

Тус судалгаагаар боловсролын салбарын эрх зүйн баримт бичиг, сургалтын хөтөлбөр зэрэгт “багш” мэргэжилтний мэдлэг, чадвар, хандлагыг тодорхойлсон байдалд дүн шинжилгээ хийхийг зорилоо. Тус зорилгын хүрээнд

• Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа 2050”

• Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого (2014-2024)

• Монгол улсын хууль Боловсролын тухай (2002)

• Монгол улсын хууль Бага дунд боловсролын тухай (2002)

• Багш бэлтгэдэг их дээд сургуулийн сургалтын хөтөлбөр зэрэгт дүн шинжилгээ хийсэн болно.

Судалгааны аргазүй:

Тус судалгааны хүрээнд МУ-ын Боловсролын салбарт хүчин төгөлдөр хэрэгжиж буй эрх зүйн баримт бичгүүдэд “багш”-ийн мэдлэг, чадвар, хандлага төлөвшилийг хэрхэн тусгасанд контент анализийн аргаар дүн шинжилгээ хийсэн. Үүнд “багш”-ийн мэдлэг, чадвар, хандлага зэргийн талаар ямар үйл үг болон нэр үгтэй холбон тайлбарласныг түүвэрлэн авч үзсэн.

Үндсэн хэсэг:

Багш хэмээх ухагдахууныг судлаач А.Янжиндолгор Монгол хэлний тайлбар толь бүтээлдээ “Эрдэм ном сурган хүмүүжүүлэгч хүн” хэмээн үзсэн бол Я.Цэвэл “Монгол хэлний товч тайлбар” тольд “Эрдэм, мэргэжил сургах хүн” хэмээн тайлбарласан. Судлаач Ш.Ичинхорлоо “Багшийн ном” бүтээлдээ “Багш бол өсвөр залуу үеийнхэнд амьдралдаа хэрэгтэй мэдлэг арга чадвар туршлага олж авахад нь туслах, тэдэнд иргэн-бие хүн төлөвших, нийгэмших процессыг шинжлэх ухааны үндэстэй зохион байгуулах мэдлэг, ур чадвар бүхий бие хүн” хэмээн тодорхойлсон бол судлаач ЧҮ.Байгалмаа “Багшийн хөгжлийн практик” номдоо багш бол “Боловсролын үйлчилгээг олон нийтэд хүргэн бие хүнийг төлөвшүүлж оюун ухаан, ажиллах ур чадвар хөгжүүлэн, мэдлэгийг суралцагчидтай хамтран үйлдвэрлэгч мэргэжилтэн” хэмээн үзжээ. Эдгээрээс “Багш”-ийг

“суралцагчдад тодорхой шинжлэх ухааны болон амьдралд хэрэгтэй мэдлэг, чадварыг заан

төлөвшүүлэхэд дэмжлэг үзүүлдэг бие хүн”

гэж үзвэл “багш мэргэжилтэн” нь “Хүүхэд, залуусын сурч танин мэдэх, хөгжих үйл ажиллагааг шинжлэх ухааны болон амьдрал практикийн мэдлэг, чадвартай хослуулан насан туршидаа сурахад дэмжлэг үзүүлдэг төлөвшсөн бие хүн” хэмээн тодорхойлж болохоор байна.

Харин мэдлэг, чадвар, хандлагын талаар тайлбар толиудад дараах байдлаар тодорхойлсон байна.

“Мэдлэг” Монгол хэлний эх тайлбар тольд “танин мэдэх үйл ажиллагааны үр дүнд тодорхой мэргэжлээр сурч боловсрол эзэмшсэн төвшин, мэдэц” гэж үзсэн бол Я.Цэвэл Монгол хэлний товч тайлбар толь бүтээлдээ “мэдсэн зүйл, мэдэц” хэмээн тайлбарлажээ.

“Чадвар”-ыг судлаач Я.Цэвэл Монгол хэлний товч тайлбар толь бүтээлдээ “чадал, мэргэжил чадвар, чадал чадвар, эрдэм чадвар” хэмээн үзсэн бол судлаач Ц.Өнөрбаян Монгол хэлний хоршоо үгийн тайлбар толь бүтээлдээ “ур чадвар нь ажил төрлийг гүйцэтгэх эв дүй” хэмээн тодорхойлсон.

“Хандлага”-ыг АНУ-ын судлаач Дэвид “Тодорхой зүйлд тодорхой байдлаар хариу үйлдэл үзүүлэхэд чиглэгдсэн, урьдчилан тогтсон, үргэлжилсэн хугацаанд тогтвортой онцлог” хэмээн үзсэн бол судлаач Д.Н.Узнаде “Субъектын хөдөлгөөнт мөн бүхэллэг шинжтэй сэтгэл зүйн байдал бөгөөд түүний тодорхой идэвхжилд бэлэн эсэхийг илэрхийнэ” хэмээн тодорхойлжээ.

“Багш” болон “мэдлэг”, “чадвар”, “хандлага” хэмээх ухагдахуунуудыг толь бичиг болон эрдэмтдийн тодорхойлсноор авч үзэхэд дээрхийн дагуу байгаа бол бид дараагийн хэсэгт 2022-2023 оны хичээлийн жилд Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль эрхзүйн орчин болон багш

бэлтгэх хөтөлбөрийн хүрэх үр дүнгүүдэд хэрхэн тодорхойлсон байгааг авч үзэх болно.

Судалгаанд хэрэглэсэн баримт бичгүүдэд багшийн “мэдлэг”-ийн талаар дараах байдлаар илэрхийлсэн байна.

Хүснэгт 1. Боловсролын эрх зүйн баримт бичгүүд дэх багшийн мэдлэг

	Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа 2050”	Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого (2014-2024)	“Монгол улсын хууль Боловсролын тухай 2002”	“Монгол улсын Бага, дунд боловсролын тухай 2002”
Мэдлэг	1.2.4. -т “Боловсролын нэгдсэн тогтолцоо, сургалтын хөтөлбөрт нүүдэлчин ахуй, зан заншил, өв соёлын агуулгыг тусгаж, цэцэрлэгт үндэсний өв соёл, уламжлалт тоглоом наадгай хангаж, хүүхэд багачууд, суралцагчдад энэ төрлийн мэдлэг” эзэмшүүлнэ 2.1.11. “... амьдрах чадварын сургалтын ... эзэмшүүлэх,”	Багшийн мэдлэгийн талаар тусган авч үзээгүй байна.	28.1.5. “иргэнд албан болон албан бус сургалтаар боловсрол эзэмшүүлэх 30.1.2. “иргэнд суурь боловсрол эзэмшүүлэх, ... мэргэжил эзэмшүүлэх	4.1.3. “хүрээлэн байгаа орчны үзэгдэл, юмсын талаар зохих шатны мэдлэг эзэмшүүлэх”; 4.1.4. “гоо зүй, хүмүүнлэг, үндэсний дэвшилт, ёс заншил, соёлын өв уламжлал, эрүүл ахуйн зохих шатны мэдлэг, ... эзэмшүүлэх”; 4.1.7. “бие дааж сурах арга барил эзэмшүүлэх”.

Эх сурвалж: Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа 2050”, Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого (2014-2024), “Монгол улсын хууль Боловсролын тухай 2002”, “Монгол улсын хууль Бага, дунд боловсролын тухай 2002”

Дээрх зүйл заалтуудаас харахад багш нь суралцагчийн амьдрал болон бие хүн болон төлөвшихөд шаардлагатай мэдлэгийг эзэмшүүлэх мэдлэгтэй байхаар тусгасан байна.

Харин багшийн “чадвар”-ын талаар дараах байдлаар тусгасан байна.

Хүснэгт 2. Боловсролын эрх зүйн баримт бичгүүд дэх багшийн чадвар

	Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа 2050”	Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого (2014-2024)	“Монгол улсын хууль Боловсролын тухай 2002”	“Монгол улсын хууль Бага, дунд боловсролын тухай 2002”
--	--	---	---	--

Чадвар	1.2.4. -т “Боловсролын нэгдсэн тогтолцоо, сургалтын хөтөлбөрт нүүдэлчин ахуй, зан заншил, өв соёлын агуулгыг тусгаж, цэцэрлэгт үндэсний өв соёл, уламжлалт тоглоом наадгай хангаж, хүүхэд багачууд, суралцагчдад энэ төрлийн чадвар” эзэмшүүлэх 2.1.6. “... <i>ажил олгогч, мэргэжлийн холбоод, эрдэмтэн багш, судлаачдын түншлэлийг</i>” бэхжүүлнэ. 2.1.12. “... <i>боловсролд тэгш хамруулна</i>”.	4.11. “... <i>иргэдийн сурах хэрэгцээ, ажлын байранд тавих шаардлагатай уялдуулан тасралтгүй хөгжүүлнэ</i>”.	28.1.5. “... <i>мэргэжлийн удирдлагаар хангах, зохицуулах;</i>” 30.1.2. “... <i>мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх, ... арга хэмжээний хөтөлбөр, төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх</i>” 44.1.2. “...<i>сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүнийг сонгон хэрэглэх</i>”; 44.1.3. “<i>суралцагч болон түүний эцэг, эх, асран хамгаалагчид шаардлага тавих, зөвлөгөө өгөх</i>”; 44.1.4. “<i>суралцагчийн мэдлэг, чадвар, дадлыг үнэлэх</i>”; 44.1.5. “<i>суралцагчийг сонгон суралцуулах, мэргэжлийн болон гүнзгийрүүлсэн сургалт зохион байгуулах</i>” 44.2.2. “<i>боловсролын стандартыг хэрэгжүүлэх</i>”; 44.2.3. “<i>онолын мэдлэг, заах арга, ур чадвараа дээшлүүлэх</i>”; 44.2.4. “<i>суралцагчдыг ялгаварлан гадуурхахгүй байх, нэр төрийг нь хүндэтгэн хамгаалах</i>”; 44.2.5. “<i>суралцагч бүр ..., өөрөө өөрийгөө хөгжүүлэх, бие хүн болж төлөвшихөд дэмжлэг үзүүлэх</i>”;	2.1. Бага боловсролын зорилго ... <i>монгол хүүхэд төлөвшүүлэх</i>, суурь боловсролын ... <i>бие даан бүтээлчээр суралцах чадамжтай иргэн төлөвшүүлэх</i>, бүрэн дунд боловсролын зорилго нь <i>мэдээлэл боловсруулах, ишидвэр гаргах</i>, ирээдүйд <i>эзэмших мэргэжлийн ерөнхий суурь чадамжтай иргэн төлөвшүүлэхэд</i>” 4.1.1. “<i>эх хэлээрээ зөв ярьж, бодол санаагаа ойлгомжтой илэрхийлэх, уншиж, бичиж сургах</i>”. эзэмшүүлэх”; 4.1.8. “<i>зөрчлийг хүчирхийллийн бус аргаар шийдвэрлэх, эрсдэлээс өөрийгөө хамгаалах мэдлэг, харилцааны ур чадвар олгох</i>”.
----------------------	--	---	---	---

Эх сурвалж: Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа 2050”,

Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого (2014-2024), “Монгол улсын хууль Боловсролын тухай 2002”, “Монгол улсын хууль Бага, дунд боловсролын тухай 2002”

Боловсролын эрх зүйн баримт бичгүүдэд багшийн “чадвар”-ууд нь эзэмшүүлэх, бэхжүүлэх, нэмэгдүүлэх,

хэрэгжүүлэх, хангах, үзүүлэх, хамруулах, хөгжүүлэх, хамгаалах, дэмжлэг үзүүлэх, сахих, шийдвэрлэх, дээшлүүлэх, зохион байгуулах, суралцуулах, үнэлэх, тодорхойлох, зохицуулах, сурах, сургах, илэрхийлэх, төлөвшүүлэх, боловсруулах зэрэг үгсээр илэрхийлэгдсэн байна.

Дээрх зүйл заалтуудаас харахад багшийн чадваруудыг харилцан адилгүйгээр тусган үзсэн байна. Тухайлбал: Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого (2014-2024) багшийн чадварыг “иргэдийн сурах хэрэгцээ, ажлын байранд тавих шаардлагатай уялдуулан тасралтгүй хөгжүүлэх” хэмээн ерөнхийлөн авч үзсэн бол МУ-ын урт хугацааны

хөгжлийн бодлого “Алсын хараа 2050”, “МУ-ын хууль Боловсролын тухай 2002”, “Монгол улсын хууль Бага, дунд боловсролын тухай 2002” зэрэгт энэ талаар тусган авч үзээгүй байна.

Судалгаанд хэрэглэсэн эрхзүйн баримт бичгүүдэд багшийн “хандлага”-ын талаар дараах байдлаар тусгагдсан байна.

Хүснэгт 3. Боловсролын эрх зүйн баримт бичгүүд дэх багшийн хандлага

	Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа 2050”	Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого (2014-2024)	“Монгол улсын хууль Боловсролын тухай 2002”	“Монгол улсын хууль Бага, дунд боловсролын тухай 2002”
Хандлага	Багшийн хандлагын талаар тусган авч үзээгүй байна.	Багшийн хандлагын талаар тусган авч үзээгүй байна.	44.2.1. “багшийн ёс зүй, нэр төрийг эрхэмлэн сахиx”; 44.2.4. “суралцагчдыг ялгаварлан гадуурхахгүй байх, нэр төрийг нь хүндэтгэн хамгаалах”; 44.2.5. “суралцагч бүрийн онцлог байдлыг хүлээн зөвшөөрч хүнлэг харьцах ...” 44.2.6. “суралцагчийн бие даасан байр суурь, үзэл бодолд хүндэтгэлтэй хандах”	4.1.6. “өөрийн болон бусдын хөдөлмөрийг хүндэтгэх, үнэнч шударга, хамтач байдлыг эрхэмлэх үзэл төлөвшүүлэх”; 2.1. Бага боловсролын зорилго... монгол хүүхэд төлөвшүүлэх, суурь боловсролын зорилго ... иргэн төлөвшүүлэх, бүрэн дунд боловсролын зорилго ... иргэн төлөвшүүлэх”

Эх сурвалж: Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа 2050”, Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого (2014-2024), “Монгол улсын хууль Боловсролын тухай 2002”, “Монгол улсын хууль Бага, дунд боловсролын тухай 2002”

Бодлогын баримт бичгүүд буюу “Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа 2050”, “Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого (2014-2024)” зэрэгт багшийн хандлагын талаар тодорхойлон авч үзээгүй байна. Харин боловсролын хуулиудад багшийн хандлагын талаар сахиx, хамгаалах,

хандах, хүндэтгэх, төлөвшүүлэх хэмээн үгсээр тусган тодорхойлон тусгажээ.

Бид судалгааны дараагийн хэсэгт дээр дурдсан хуулиудад туссан зүйл заалтуудыг багш бэлтгэх их дээд сургуулиуд сургалтын хөтөлбөрийн хүрэх үр дүндээ хэрхэн тусгасныг төрийн өмчийн болон төрийн бус өмчийн 2 их сургуулийн хөтөлбөрт дүн

шинжилгээ хийн судаллаа.
“Багшийн мэдлэг”-ийг хэрхэн
тодорхойлсон авч үзвэл:

Хүснэгт 4. “Төрийн өмчийн болон төрийн бус өмчийн их сургуулийн сургалтын хөтөлбөрийн хүрэх үр дүн дэх “багшийн мэдлэг”-н талаарх зүйл заалтууд

	<i>Төрийн өмчийн их сургуулийн сургалтын хөтөлбөрийн хүрэх үр дүн</i>	<i>Төрийн бус өмчийн их сургуулийн сургалтын хөтөлбөрийн хүрэх үр дүн</i>
Мэдлэг	3.1.4. “Боловсролын онол, үзэл баримтлал, бодлого, эрх зүй, стандарт тэдгээрийн хэрэгжилт ” 3.2.1. “Суралцагчдын хувийн ялгаа, хэрэгцээ, сонирхол, суралцах хэв шинж ” 3.2.2. “Суралцахуйн зонхилох онол, үзэл баримтлал ”	Эх хэл, математик, байгалийн ухаан, гоо зүйн суурь мэдлэгтэй

Төрийн өмчийн их сургууль нь сургалтын хөтөлбөртөө эрхзүйн баримт бичгүүдэд туссан агуулгуудыг тодорхой хэмжээнд тусган хүрэх үр дүнгүүдээ тодорхойлсон байна. Харин төрийн бус өмчийн их сургууль нь эх хэл, математик, байгалийн ухаан, гоо

зүйн суурь хэмээн ерөнхийлөн тусгажээ.

Төрийн өмчийн болон төрийн бус өмчийн их сургуулийн сургалтын хөтөлбөрийн хүрэх үр дүн дэх “Багшийн чадвар”-ыг тодорхойлсон байдлыг авч үзвэл:

Хүснэгт 5. “Төрийн өмчийн болон төрийн бус өмчийн их сургуулийн сургалтын хөтөлбөрийн хүрэх үр дүн дэх “багшийн чадвар”-н талаарх зүйл заалтууд

	<i>Төрийн өмчийн их сургуулийн сургалтын хөтөлбөрийн хүрэх үр дүн</i>	<i>Төрийн бус өмчийн их сургуулийн сургалтын хөтөлбөрийн хүрэх үр дүн</i>
--	---	---

Чадвар	1.1.2. “Хүүхэд бүрт амжилттай сурч чадна гэдэг итгэл өгөх, ... хөтлөх, туслах” 1.1.3. “... амжилт, ахиц дэвшлийг урамшуулах, үнэлэх” 1.1.4. “Суралцах үйл ажиллагааг чиглүүлэх, зөвлөх” 3.2.5. “... суралцах чадамж, сурах арга барил, түүнийг төлөвшүүлэх, хөгжүүлэх” 3.3.4. “...бүлэг, анги хамт олонтой ажиллах” 3.3.5. “Сургалтын явцын, үр дүнгийн үнэлгээ, ... судалгаа хийх чадвар” 3.4.2. “ ... үйл ажиллагааг зохион байгуулах, үнэлгээ дүгнэлт өгөх” 3.4.3. “... хамтарч ажиллах, харилцан суралцах үйлийг дэмжих” 3.5.1. “Тухайн хичээлээр эзэмших мэдлэгийг хэрхэн бүтээх, ... амьдралд хэрэглэх” 3.5.2.”... агуулгыг судлахад тулгардаг түгээмэл алдаа, тэдгээрийг залруулах ...” 3.5.3. “... хичээл, сургалтын үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, ...үнэлэх, үр дүнг танилцуулах” 3.6.2. “Сорил, туршилтаар мэдлэг бүтээх арга зүйг төлөвлөх, хэрэгжүүлэх, сайжруулах” 3.6.3. “... мэдлэг бүтээлгэх арга зүйг төлөвлөн хэрэгжүүлж чаддаг” 3.6.4. “... арга барилд суралцах үйл ажиллагааг төлөвлөх” 3.6.5. “... асуудлыг бүтээлчээр шийдвэрлэх” 4.3.1. “... сэтгэн бодохуйг дэмжсэн арга зүй эзэмших, хүүхэд бүрийн хөгжлийг дэмжих” 4.3.2. “Сургалтыг дэмжих үйл ажиллагааг зохион байгуулах...” 4.3.3. “Олон хувилбарт үнэлгээний арга зүй боловсруулах, хүүхдийн хөгжлийн ахиц, өөрчлөлтийг ... хөтлөх, үнэлэх” 4.3.4. “... сурагчдын хэрэгцээ сонирхол, ... оролцоог дэмжих орчин бүрдүүлэх,	“... бага насны хүүхэдтэй ажиллах эв дүйтэй, хүүхдийн бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх арга барилд суралцсан, харилцааны болон мэдээллийн техниктэй ажиллах”
--------	---	--

Төрийн өмчийн болон төрийн бус өмчийн их сургуулийн сургалтын хөтөлбөрийн хүрэх үр дүн дэх багшийн чадварыг харьцуулан судлахад нийт 35 үйл үгийг ашигласан бөгөөд үүнээс хамгийн их давтагдаж буй үг нь “төлөвлөх”-5, “зохион байгуулах”-4, “ажиллах”-3, “төлөвшүүлэх, хөгжүүлэх”-2 тус тус байна. Үүнээс үзэхэд багшийн чадварыг хичээл сургалтын үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, хүүхэдтэй болон техниктэй

хамтарч ажиллах, хүүхдийг төлөвшүүлэх, хөгжүүлэх талаас нь авч үзсэн байна. Өмнөх хэсэгт авч үзсэн хуулийн зүйл заалтуудад гарсан агуулгуудыг төрийн өмчийн болон төрийн бус өмчийн их сургуулиудын сургалтын хөтөлбөрийн хүрэх үр дүнгүүдэд харилцан адилгүй илэрч байна.

Тус сургуулиудын сургалтын хөтөлбөрийн хүрэх үр дүн дэх “Багшийн хандлага”-ыг тодорхойлсон байдлыг авч үзвэл:

Хүснэгт 6. “Төрийн өмчийн болон төрийн бус өмчийн их сургуулийн сургалтын хөтөлбөрийн хүрэх үр дүн дэх “багшийн хандлага”-н талаарх зүйл заалтууд

	Төрийн өмчит их сургуулийн сургалтын хөтөлбөрийн хүрэх үр дүн	Төрийн бус өмчийн их сургуулийн сургалтын хөтөлбөрийн хүрэх үр дүн
Хандлага	1.2.1. “Багшийн нэр хүнд ёс зүй, төрийн хууль, дүрэм, журам сахин мэдэх, мөрдөх, үлгэрлэх” 1.2.2. “Бусдыг <i>дэмжих</i>, хамтран ажиллагчдын үүрэг, хувь нэмрийг <i>үнэлэх, илэрхийлэх</i>” 1.2.3. “Баг, нийтийн эрх ашгийг <i>дээдлэх</i>, шинэчлэл, шинэ санааг соргог <i>мэдрэх</i>” 1.2.4. “Эцэг эх, хүүхдийн <i>боловсрол</i> олж авах үйл ажиллагаанд <i>оролцуулах, харилцах, итгэл, үнэмшил бий болгох</i>” 1.2.5. “Багшлах <i>ажилдаа</i> чин сэтгэлээсээ <i>ажил хэрэгч, хариуцлагатай, тууштай хандах итгэл үнэмшил бий болгох</i>” 4.1.3. “Хүүхэд бүрийн ялгаатай байдлыг <i>ойлгодог, хүндэтгэлтэй хандаг</i>, хүүхэд бүрийг сурч чадна гэдэгт <i>итгэдэг, тэмүүлдэг ...</i>” 4.2.2. “... дэлхийн улс орнуудын <i>түүх, соёл</i> ба бусад урлагийн төрлүүдтэй холбон <i>судалж</i>, өөрийн болон бусдын <i>соёлд хүндэтгэлтэй</i> хандаг” 4.2.5. “Тухайн орон нутгийн <i>биет болон биет бус соёл, урлагийг хөгжүүлэхэд</i> мэргэжил, арга зүйн <i>дэмжлэг үзүүлэх эрмэлзэлтэй...</i>”. 4.2.6. “Хувийн урын сангаа <i>баяжуулан</i>, өөрийгөө тасралтгүй <i>хөгжүүлдэг, урлагийг ойлгодог</i> нарийн мэдрэмжээрээ <i>хүүхдийн ойлгож</i>, тэдэнд <i>хүндэтгэлтэй хандаг</i>”. 4.5.4. “Нийгмийн хариуцлагаа <i>ухамсарлах</i>, олон нийтийн үйл ажиллагаанд <i>оролцох</i>” 4.5.5. “Баг, хамт олны гишүүн гэдгээ <i>мэдэрч</i>, шийдвэр гаргалтад хувь нэмрээ <i>оруулах</i>, аливаад эсрэг <i>хандах</i>”	Багшийн хандлагын талаар тусган авч үзээгүй байна.

Төрийн өмчийн болон төрийн бус өмчийн их сургуулийн сургалтын хөтөлбөрийн хүрэх үр дүн дэх багшийн хандлагыг тусгасан байдлыг судлахад нийт 29 үйл үгээр илэрхийлснээс “хүндэтгэдэг”- 4, “төлөвшүүлэх”- 4, “итгэл үнэмшил бий болгодог”- 2, “дэмждэг”- 2 удаа зэрэг давтагдсан байна. Дүгнэж үзэхэд төрийн өмчийн их сургуулийн сургалтын хөтөлбөрийн хүрэх үр дүнд “Багшийн хандлага”-ыг хүүхэд бүрийн ялгаатай байдал, өөрийн болон бусдын хөдөлмөр, өөрийн болон бусдын соёлд ялгаа,

хүүхдийг ойлгон хөгжихөд нь хүндэтгэлтэй хандах, зөв монгол хүүхэд, иргэнийг төлөвшүүлэх, ажилдаа чин сэтгэлээсээ дуртай, итгэл үнэмшил бий болгодог, хүүхэд суралцагч болон бусдыг дэмждэг байх зэргээр тусгажээ. Харин төрийн бус өмчийн их сургуулийн хувьд сургалтын хөтөлбөрийн үр дүндээ бэлтгэгдэн гарч буй багшийн хандлагын талаар тусгаагүй байна.

Дээрх баримт бичгүүдэд илэрч буй үр дүнгүүдийг *textmining* программаар шинжилж үзэхэд “багш”-ийг хүчин төгөлдөр

Дүгнэлт:

Боловсролын эрх зүйн баримт бичиг, багш бэлтгэх сургалтын хөтөлбөрийн хүрэх үр дүнд багш мэргэжилтний “мэдлэг”, “чадвар”, “хандлага” хэрхэн туссанд хийсэн дүн шинжилгээг нэгтгэн дараах дүгнэлтэд хүрч байна.

1. Багш мэргэжилтнийг “өөрийгөө судалж танин мэдсэн, цаашид сурч хөгжих арга барилаа тодорхойлохын зэрэгцээ мэргэжлийн мэдлэг, чадвар, хандлага төлөвшилтэй бие хүн” хэмээн тодорхойлж болохоор байна.

2. Боловсролын салбарт хүчин төгөлдөр мөрдөгдөж буй эрхзүйн баримт бичгүүдэд багшийн “мэдлэг”, “чадвар”, “хандлага”-ыг тодорхойлон тусгахдаа хэтэрхий ерөнхий байдлаар тусгасан ба багш нь суралцагчдад мэдлэгийг олгодог, төлөвшүүлэн хүмүүжүүлдэг гэх үзэл санааг агуулсан багш төвтэй үзлийг баримталсан зүйл заалтууд нилээдгүй байгаа суралцагч төвтэй үзэл баримтлад суурилсан болон орчин үеийн боловсролын шинэчлэлүүдтэй (цахим шилжилт, хиймэл оюун ухаан, суралцагчийн онлог гэх мэт) холбоотой зүйл заалтууд дутмаг байна.

3. Боловсролын эрх зүйн баримт бичиг, багш бэлтгэх сургалтын хөтөлбөрийн хүрэх үр дүнд багшийн мэдлэг, чадвар, хандлагыг тодорхойлон үзэхэд харилцан адилгүй байдлаар тусгасан байна.

4. Боловсролын салбарын эрх зүйн баримт бичигт багш мэргэжилтний мэдлэг, чадвар, хандлагын талаар нэгдсэн байдлаар тусгаж, баримт бичгүүдийн залгамж холбоог харгалзан үзэх.

5. Багш бэлтгэдэг их дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт багшийн мэдлэг, чадвар, хандлага зэргийг тусгахдаа салбарын эрхзүйн үзэл баримтлалыг харгалзан үзэх.

НОМ ЗҮЙ:

МУ-ын хууль Боловсролын тухай 2002.

МУ-ын хууль Бага, дунд боловсролын тухай 2002.

Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого (2014-2024).

Алсын хараа 2050 Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого. Улаанбаатар хот.

<https://mongoltoli.mn/> Монгол хэлний эх тайлбар толь.

Гэлэгжамц Ц. (2000). *Монгол улсын Ерөнхий дунд боловсролын эрх зүйн зохицуулалт.* Улаанбаатар хот.

Идэр их сургууль. “Бага ангийн багш” бэлтгэх хөтөлбөрийн үр дүн.

Монгол улсын боловсролын их сургууль. “Бага ангийн багш” бэлтгэх сургалтын хөтөлбөрийн үр дүн.

Өнөрбаян Ц. нар., (2019). *Монгол хэлний хоршоо үгийн толь.* Улаанбаатар хот., Бэмби сан ХХК.

Цэвэл Я. (2013). *Монгол хэлний товч тайлбар толь.* Улаанбаатар хот.

Янжиндолгор А. нар., (2018). *Монгол хэлний тайлбар толь.* Улаанбаатар хот., Монсудар хэвлэлийн газар.